



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/002/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn

Даланзадгад хот

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Шижирболд

Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
<i>2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан</i> <i>/төгрөгөөр/</i>	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
<i>2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан</i> <i>/төгрөгөөр/</i>	6
<i>2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан</i> <i>/төгрөгөөр/</i>	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Төлбөрийн акт	9
Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.	9
3.2 Албан шаардлага	9
3.3 Зөвлөмж	9

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.09.20 № 332
танай _____-ны № _____-т

Г ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НИЙГМИЙН Г
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ОРГИЛБОЛД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нийгмийн даатгалын сангийн сикос программын шинэчлэл хийгдэж санхүүгийн тайланг хуулийн цагалбарт хугацаанд гаргаж ирүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд орлогыг 235,977.1 сая төгрөг, зардлыг 115,628.8 сая төгрөгөөр төсөвлөж, гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөөг 98.85 хувь, зардлын төлөвлөгөөг 99.99 хувьтай биелүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант хугацаанд харилцагчаас ирсэн 16,567 цахим хүсэлтийг шийдвэрлэж ажилласан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4626050508
F:\2.Бичиг хэрэг\2026он\СТА-н дүгнэлт\Төсвийн ДТ

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,520,489,110.30	36,151,562,814.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,684,019,275.44	3,675,923,538.53
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	6,684,019,275.44	3,675,923,538.53
31210	Төгрөг	6,684,019,275.44	3,675,923,538.53
31213	Арилжааны банк дахь харилцах	6,684,019,275.44	3,675,923,538.53
33	АВЛАГА	24,836,469,834.86	32,475,639,276.27
33300	Татаас, санхүүжилтийн авлага	11,811,695,866.03	11,811,695,866.03
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	12,910,726,982.81	20,561,019,119.01
33500	Бусад авлага	114,046,986.02	102,924,291.23
33510	Байгууллагаас авах авлага	10,184,521.28	20,138,027.41
33520	Хувь хүмүүсээс авах авлага	103,862,464.74	82,786,263.82
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	31,520,489,110.30	36,151,562,814.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,522,661,070.94	5,328,114,110.11
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,522,661,070.94	5,328,114,110.11
41300	Өглөг	709,913,464.71	2,105,522,729.64
41360	Бусад өглөг	709,913,464.71	2,105,522,729.64
41361	Байгууллагад төлөх өглөг	3,785,224.95	13,792,445.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	706,128,239.76	2,091,730,284.64
41400	Урьдчилж орсон орлого	2,812,747,606.23	3,222,591,380.47
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	2,812,747,606.23	3,222,591,380.47
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	27,997,828,039.36	30,823,448,704.69
51	Засгийн газрын хувь оролцоо	27,997,828,039.36	30,823,448,704.69
51200	Хуримтлагдсан үр дүн	27,997,828,039.36	30,823,448,704.69
51210	Өмнөх үеийн үр дүн	25,632,528,754.06	27,621,817,005.68
51220	Тайлант үеийн үр дүн	2,365,299,285.30	3,201,631,699.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	31,520,489,110.30	36,151,562,814.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	289,284,996,876.75	353,501,778,997.71
11	ТАТВАРЫН ОРЛОГО	189,965,261,572.01	240,163,039,749.37
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	189,965,261,572.01	240,163,039,749.37
1122	Тэтгэврийн даатгалын шимтгэл	155,786,051,131.58	195,321,204,732.63
112001	Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	155,786,051,131.58	195,321,204,732.63
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	16,396,425,309.32	20,764,510,875.71
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	12,259,209,652.33	16,904,171,978.36
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	5,523,575,478.78	7,173,152,162.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	89,404,838.59	113,338,739,248.34
120	Нийтлэг татварын бус орлого	89,404,838.59	229,578,413.34
1201	Хүүгийн орлого	69,006,920.42	54,180,874.30
120002	Бусад хүүгийн орлого	69,006,920.42	54,180,874.30
120003	Торгуулийн орлого	-	19,890,900.00
120009	Бусад орлого	20,397,918.17	155,506,639.04
122	Тусламжийн орлого	-	113,109,160,835.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	113,109,160,835.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	27,414,283,000.00
122152	НДС-д УТ-с олгох татаасын орлого \УТ-НДС\	-	27,414,283,000.00
122004	НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого	-	85,694,877,835.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	99,230,330,466.15	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	22,772,274,253.15	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	22,772,274,253.15	-
1330	Төсвийн захирагчдаас	76,458,056,213.00	-
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,458,056,213.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	286,919,697,591.45	350,300,147,298.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	286,919,697,591.45	350,300,147,298.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,584,690.00	12,069,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,584,690.00	12,069,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,140,000.00	7,435,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,444,690.00	4,634,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	286,905,112,901.45	350,288,077,498.70
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	233,399,234,962.91
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	233,399,234,962.91
213104	НДС-н орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	233,399,234,962.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	99,616,829,464.70	116,888,842,535.79
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	99,616,829,464.70	116,888,842,535.79
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	187,288,283,436.75	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	187,288,283,436.75	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,365,299,285.30	3,201,631,699.01
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	2,365,299,285.30	3,201,631,699.01

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	320,985,663,354.19	390,774,068,846.54
11	ТАТВАРЫН ОРЛОГО	221,914,988,280.41	233,103,348,944.37
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	221,914,988,280.41	233,103,348,944.37
1122	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	149,799,307,187.37	189,750,040,375.00
112001	Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	149,799,307,187.37	189,750,040,375.00
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	15,825,010,109.36	20,103,031,629.05
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	16,653,263,648.60	16,307,571,777.54
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	5,863,181,526.01	6,942,705,162.78
1121	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого	33,774,225,809.07	-
112005	Бусад эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого	33,774,225,809.07	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	133,384,860.78	157,670,719,902.17
120	Нийтлэг татварын бус орлого	133,384,860.78	44,561,559,067.17
1201	Хүүгийн орлого	70,716,095.30	54,479,184.50
120002	Бусад хүүгийн орлого	70,716,095.30	54,479,184.50
120009	Бусад орлого	62,668,765.48	44,507,079,882.67
122	Тусламжийн орлого	-	113,109,160,835.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	113,109,160,835.00
12215	Төсөв хоорондын хандив, тусламж	-	27,414,283,000.00
122152	НДС-д УТ-с олгох татаасын орлого \УТ-НДС\	-	27,414,283,000.00
122004	НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого	-	85,694,877,835.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	98,937,290,213.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	22,479,234,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	22,479,234,000.00	-
1330	Төсвийн захирагчдаас	76,458,056,213.00	-
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,458,056,213.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	321,596,186,169.83	393,782,164,583.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	321,596,186,169.83	393,782,164,583.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	142,581,957.02	91,202,153.78
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,584,690.00	12,069,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,140,000.00	7,435,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,444,690.00	4,634,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,997,267.02	79,132,353.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	127,997,267.02	79,132,353.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	321,453,604,212.81	393,690,962,429.67
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	278,084,142,693.80
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	278,084,142,693.80

213104	НДС-ын орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	278,084,142,693.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	99,070,340,491.94	115,606,819,735.87
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	99,070,340,491.94	115,606,819,735.87
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	222,383,263,720.87	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	222,383,263,720.87	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	-
		610,522,815.64	3,008,095,736.91
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
		610,522,815.64	3,008,095,736.91
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,294,542,091.08	6,684,019,275.44
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,684,019,275.44	3,675,923,538.53

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Хяналтын бус хувь оролцоо	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	27,997,828,039.36	-	27,997,828,039.36
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-376,011,033.68	-	-376,011,033.68
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	27,621,817,005.68	-	27,621,817,005.68
Тайлант үеийн үр дүн	-	3,201,631,699.01	-	3,201,631,699.01
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	30,823,448,704.69	-	30,823,448,704.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	263,391,358,500.00	260,671,014,423.29	2,720,344,076.71	98.97
11	Татварын орлого	235,977,075,500.00	233,256,731,423.29	2,720,344,076.71	98.85
112	Нийгмийн даатгалын орлого	235,977,075,500.00	233,256,731,423.29	2,720,344,076.71	98.85
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	199,097,745,400.00	189,844,562,570.24	9,253,182,829.76	95.35
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	17,685,138,000.00	20,115,746,048.19	- 2,430,608,048.19	113.74
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	12,072,709,300.00	16,308,062,007.71	-4,235,352,707.71	135.08
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	7,121,482,800.00	6,988,360,797.15	133,122,002.85	98.13
12	Татварын бус орлого	27,414,283,000.00	27,414,283,000.00	-	100.00
122	Тусламжийн орлого	27,414,283,000.00	27,414,283,000.00	-	100.00
122001	Хандив тусламж /дотоод/	27,414,283,000.00	27,414,283,000.00	-	100.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	115,628,832,500.00	115,618,889,535.87	9,942,964.13	99.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	115,628,832,500.00	115,618,889,535.87	9,942,964.13	99.99

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,143,100.00	12,069,800.00	11,073,300.00	52.15
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,143,100.00	12,069,800.00	11,073,300.00	52.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,197,200.00	7,435,000.00	2,762,200.00	72.91
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	12,945,900.00	4,634,800.00	8,311,100.00	35.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,605,689,400.00	115,606,819,735.87	- 1,130,335.87	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,605,689,400.00	115,606,819,735.87	-1,130,335.87	100.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	115,605,689,400.00	115,606,819,735.87	-1,130,335.87	100.00
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	147,762,526,000.00	145,052,124,887.42	2,710,401,112.58	98.17
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-147,762,526,000.00	-145,052,124,887.42	-2,710,401,112.58	98.17
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-147,762,526,000.00	-145,052,124,887.42	-2,710,401,112.58	98.17
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,684,019,275.44	-6,684,019,275.44	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,675,923,538.53	-3,675,923,538.53	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,359.5 сая төгрөгийн 2 зөрчил¹ илэрснээс 7,639.2 сая төгрөгийн зөрчилд нэг албан шаардлага, 2,720.3 сая төгрөгийн нэг зөрчилд дотоод хяналтыг сайжруулж үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлж ажиллах нэг зөвлөмж өглөө.

Тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар материаллаг зөрчил илрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт: 1 Тайлант хугацаанд 32,475.6 сая төгрөгийн авлагатай тайлагнасан нь өмнөх оноос 7,639.2 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг харуулав. Үүнд:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Дотоод хяналт сайжруулахтай холбоотой асуудал

Илрүүлэлт:1 Тайлант хугацааны орлогын гүйцэтгэл 2,720.3 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөөт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн орлого тасарч байгаа шалтгааныг тодорхойлж, арга хэмжээ авч орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2027 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТ-ны тоо	Тоо	Дүн	
Тайлант хугацаанд 32,475.6 сая төгрөгийн авлагатай тайлагнасан нь өмнөх оноос 7,639.2 сая төгрөгөөр өссөн	1	7,639.2			1	7,639.2							
Тайлант хугацааны орлогын гүйцэтгэл 2,720.3 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн	1	2,720.3					1	2,720.3					
Дүн	2	10,359.5			1	7,639.2	1	2,720.3					